

# ЖЕНДЭРИЙН ТАЛААРХ ҮНДСЭН ОЙЛГОЛТ



УЛААНБААТАР 2022

3 ЦУВРАЛ  
НОМЫН  
2-Р ДЭВТЭР

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төслийн хүрээнд НҮБ-ын хүн амын сангийн техник, арга зүйн дэмжлэгтэйгээр хэвлүүлэв.

“Би Си Ай” ХХК-д хэвлэв.



# ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХУЧИРХИЙЛЛИЙГ ТАСЛАН ЗОГСООЁ!

Жендэрийн талаар уншиж судлахын өмнө дараах асуулгыг бөглөж, мэдлэг ойлголтоо тандаарай. Үндэслэл, тайлбар хэсэгт өөрийн бодлоо тодорхой бичээрэй.

№	Асуулт	Эрэгтэй	Эмэгтэй	Үндэслэл, тайлбар
1	"Тогооч"-ийн ажлыг ямар хүйсний хүн хийвэл тохиромжтой гэж боддог вэ?			
2	"Инженер"-ийн ажлыг ямар хүйсний хүн хийвэл тохиромжтой гэж боддог вэ?			
3	Үр хүүхдээ өсгөж, хүмүүжүүлэхэд эхнэр, нөхрийн хэн нь голлох үүрэгтэй байх ёстой гэж боддог вэ?			
4	Эхнэр нөхрүүд гадуур мал аж ажуйн ажлаа хийж ирээд хэн нь гэрийнхээ ажлыг түлхүү хийх үүрэгтэй вэ?			
5	Аль хүйсийн суралцагчид зайлшгүй боловсрол эзэмших ёстой гэж боддог вэ?			

3 ЦУВРАЛ  
НОМЫН  
2-Р ДЭВТЭР

## СЭДЭВ 1

# ЖЕНДЭРИЙН ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ



Жендэр гэдэг нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн талаарх нийгмийн зүгээс бий болгосон хэм хэмжээ, үүрэг, дүр төрх, хандлагын ялгааг хамаарах ойлголт юм. Жендэрийн хэм хэмжээ гэдэг нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хувьд хийж болох, болохгүй зүйлсийн талаарх нийгмийн хүлээлт юм. Харин жендэрийн үүрэг гэдэг нь тухайн нийгэм, хамт олон, нийгмийн бүлгийн хувьд ямар үүргийг оноож, ямар дүр төрхийг эрэгтэйлэг, мөн эмэгтэйлэг гэж үздэгийг харуулах ойлголт юм. Эдгээр хэм хэмжээ болон дүр төрх нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн өдөр тутмын үйл ажиллагааг нь хязгаарлаж байдаг ба эмэгтэйчүүдийг хараат, захирагдмал байлгахад нөлөөлдөг. Жишээ нь манай нөхцөлд хүүхдүүдэд, хөвгүүд биш охидууд аяга таваг угаах, хоол хийх зэрэг гэрийн ажилд туслах ёстой, эрэгтэй хүн гэр бүлийн тэргүүн байх, гэр бүлээ тэжээх үүрэгтэй гэсэн хэм хэмжээ үйлчилж, эрэгтэйчүүдийг зоригтой, хүчтэй, шийдэмгий, эмэгтэйчүүдийг сул дорой, уян зөөлөн, ялдам гэсэн дүр төрхөөр хэмжих нь их байдаг."

Жендэрийн энэхүү хэм хэмжээ, хэвшмэл дүр төрх, нийгмийн хандлага, ойлголт нь эмэгтэйчүүдийн хувьд, нөхөр нь шийдвэр гаргах ёстой гэдгийг хүлээн зөвшөөрөх, нөхрийнхөө үгийг дагах, хүчирхийллийг тэвчих, хүлээн зөвшөөрөх хандлагыг дэмжсэн байдгаараа үүнийг арилгахад бэрхшээл болж байна. Мөн манай улсын хувьд патриарх буюу эцгийн эрхт ёсыг дээдэлсэн соёл, уламжлал нь эрэгтэй эмэгтэй хүний нийгэм, гэр бүлд эзлэх байр суурийг ялгаатай байдлаар тодорхойлох ойлголт, хандлагыг нийгэмд бий болгож байдаг. Ялангуяа хөдөө орон нутагт энэ хандлага нь илүүтэй ажиглагдаж байгааг олон судалгааны тайланд дурдах байдаг.

*Дараах дасгалаар хүйс болон жендэрийн хоорондох ялгааны талаар мэдлэгээ шалгана уу.*

Жендэр гэдэг нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хувьд нийгмээс бий болгосон хэм хэмжээ, үүрэг, дүр төрх, нийгмийн хандлагын ялгааг хамаарах ойлголт, нэр томьёо бөгөөд энэ нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст аль алинд нь хамаарна. Харин хүйс гэдэг нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн биологийн болон генетикийн хувьд ялгагдах шинжүүдийг хамаарсан ойлголт юм. Эдгээр шинжүүд нь хувирч өөрчлөгдөхгүй /мэс ажилбар, болон дааврын эмчилгээнээс бусад тохиолдолд/, нийтлэг шинжтэй байдаг.



Жендэр болон хүйсийн ялгааг тодорхойлон, үргэлжлүүлэн тэмдэглэнэ үү?

Үүрэг	Хүйсийн ойлголт	Жендэрийн ойлголт	Тайлбар
Хүүхэд хөхүүлэх	+		
Хоол хийх		+	
Удирдан жолоодох			
Сахлаа ургуулах			
Бокс тоглох			
Дуу хоолой нь өөрчлөгдөх			
Сүлжих нэхэх			
Шийдвэр гаргах			




Жендэрийн тэгш байдал гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ.





*Яагаад жендэрийн тэгш байдлыг хангах нь чухал вэ?*

Жендэрийн тэгш байдлыг хангах нь улс орны хөгжлийн үндэс юм. Ямар ч хүн өөрийн хүйсээс үл хамааран, нөөц бололцоогоо бүрэн дайчилж ажиллаж, амьдрах эрхээ эдлэх ёстой. Гэтэл нийгмийн хэвшмэл ойлголт, ялгаварлан гадуурхсан хандлага, ажил үүргийн тэгш бус хуваарилалтаас болж эмэгтэйчүүд өөрийн нөөц бололцоогоо дайчлах, эдлэх боломжоо тэр бүр эдэлж чадахгүй байдаг.



Өвгөөн, шинэ хүн маань охин байсан нь дээр үү, эсвэл хүү юу?

Удам залгах хүүтэй болвол зүгээр шүү. Охин хүүхэд ч хүний л хүн гэсэн үг. Эр хүн гэдэг ч бас хийморь нь хаачих вэ дээ



Батсайхан минь орчин цагт ингэж хөнгөн яривал буруудах болсон шүү. Аав ээжээ ачилж, улс орондоо хэрэгтэй, үр хүүхдэдээ түшигтэй хүн болвол хүү охины ялгаа үгүй болсон санагддаг.



Тэгээд ч удмынхаа нэр хүндийг мандуулж яваа мундаг эмэгтэйчүүд олон болсон шүү дээ. Заавал эрэгтэй хүүхэд удам судрынхаа нэр төрийг авч явах мэт үздэг нь буруу болжээ, хөө.

Нээрээ ч тийм дээ, чадалтай мундаг эмэгтэйчүүд ч нийгэмд их болсон байна. Хүн өөрөө хичээвэл эрэгтэй, эмэгтэйн ялгаа нээрээ байхгүй шүү.



## ДУГИЭЛТ:

Жендэрийн ялгаатай үнэлэмж нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс ийм байх ёстой гэж нийгмээс тогтоосон нийтлэг дүр төрх, стандартаас үүддэг. Гэтэл эрэгтэй, эмэгтэй хүний жинхэнэ үр чадвар, нийгэмд оруулах хувь нэмэр, нийгэм, гэр бүлд эзлэх байр суурь тэдний хүйсээс бус харин тэдний үр ухаан, сурсан мэдсэн мэдлэг чадвар, хөдөлмөрч байдал, хандлагаас л хамаарна.




Хүйсийн ялгаатай байдлыг өөгшүүлж, эрэгтэйчүүд заавал ар гэртээ илүү их орлого олох эсвэл, эмэгтэйчүүд дан ганц гэрийн ажлаа нугалах ёстой гэх мэт нь хоцрогдсон хэвшмэл үзэлд тооцогдох бөгөөд орчин цагийн амьдралын хэв маяг болоод хувь хүний нийгэмд оруулах хувь нэмэрт сөргөөр нөлөөлөх хүчин зүйл юм.

Сувдаа Батсайхан нарын хооронд болж буй харилцан яриа нь та бидний өдөр тутмын амьдралд нийтлэг тохиолддог бөгөөд жендэр, хүйсийн талаарх өөрийн ойлголт, мэдлэгтээ тулгуурлан гэр бүл эсхүл найз нөхөдтэйгээ уг яриаг дүгнэн ярилцаарай.



## СЭДЭВ 2

# ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ БА ЭРХ МЭДЛИЙН УЯЛДАА




Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ) гэж юу вэ? Жендэрт суурилсан хүчирхийлэл гэдэг нь нийгмийн тогтоосон жендэрийн "Дүр", хэвшмэл ойлголт, хүлээлт, хэм хэмжээнд үндэслэн үйлдэгдэж, бусдад зовиур, шаналал учруулж буй санаатай үйлдэл юм. Өөрөөр хэлбэл, жендэрт суурилсан хүчирхийлэл гэдэг нь хүйсээс үүдэлтэй нийгмийн хүлээлт, хэм хэмжээ, хандлага, хэвшмэл ойлголт болон эрх мэдэл, хүчний тэнцвэргүй байдлын улмаас бусдын эсрэг үйлдэгдэж байгаа аливаа хүчирхийллийг ойлгоно. ЖСХ нь ихэвчлэн эмэгтэйчүүдийн эсрэг тэднийг эмэгтэй хүн гэдэг тэгш бус байдлаар хандахад нөлөөлдөг. Түүнчлэн хөвгүүд "Эр хүн" гэсэн хэвшмэл тогтсон ойлголттой холбоотойгоор хүчирхийллийн хохирогч болох тохиолдол цөөнгүй байдаг. Олон хүн жендэрт суурилсан хүчирхийллийг бие махбодын хүчирхийлэл гэж ойлгодог боловч дээр дурдсан шалтгаанаар үйлдэгдэж байгаа бие махбодын хүчирхийлэл, сэтгэл санааны хүчирхийлэл, эдийн засгийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл зэрэг хүчирхийллийн бусад хэлбэрүүд ч мөн үүнд ордог.

**Эрх мэдэл:** Өөрт хамаатай асуудлаар шийдвэр гаргах, өөрийн сонголтыг хэрэгжүүлэх, эсвэл бусдын сонголтод нөлөөлөхөд зэрэгээр ч, бас сөргөөр ч ашиглаж болох хүч, чадал юм. Хэн нэгэн эрх мэдлээ бусдыг хянах, эрхшээлдээ байлгах, эрхийг нь хязгаарлах хэлбэрээр хэтрүүлэн ашиглах нь хүчирхийлэл мөн.







## Дасгал ажил

**Доорх тохиолдын аль нь жендэрт суурилсан хүчирхийлэлд тооцогдох вэ ?**

№	Өгөгдөл	Хүчирхийлэл мөн	Хүчирхийлэл биш
1	Хайртай бол хартай учраас нөхөр нь эхнэрийнхээ утсыг үе үе шалгаж үздэг.		
2	Сувдаа дахин хүүхэдтэй болохыг хүсэхгүй байна гэхэд нөхөр нь удам залгах хүүтэй болмоор байна гэж шаардсаар зөвшөөрүүлэв.		
3	Алтан их сургуульд сурахыг хүссэн ч авд нь мал маллах хүн хүч хэрэгтэй байсан тул сургуульд явуулаагүй байна.		
4	Туяа сумын төв ороод ирэхийн тулд үргэлж нөхрөөсөө асууж, зөвшөөрөл авдаг.		
5	Туяагийн хадам ээж нь Туяаг бусад хамаатнуудынх нь өмнө арчаагүй гэж хэлсэн байна.		



Зөв хариулт. Дээрх бүх тохиолдол жендэрт суурилсан хүчирхийлэл мөн юм. Хүчирхийлэл нь маш олон арга хэлбэрээр илэрч болох ба ихэнхи тохиолдолд хохирогчид хүчирхийлэлд өртөж байгаагаа мэддэггүйн улмаас хүчирхийллийг таслан зогсоож чаддаггүй байна.

**Дасгал ажил 3:** Хэрвээ та гэр бүлтэй бол дараах асуултуудад хариулна уу? Эдгээр асуултууд нь танд өөрийн эрх мэдлийн тэнцвэрээ үнэлэхэд тусална. Асуулт бүрт тохирох оноог сонгоно уу (1= Хэзээ ч үгүй, 2= Хааяа, 3= Заримдаа, 4= Ихэвчлэн, 5=Байнга/Тогтмол)

№	Асуулт	Оноо
1	Та хоёр хоёулаа бие биеэсээ эн тэнцүү талархал, магтаал, урмын үгийг сонсдог уу?	
2	Та хоёр харилцан нэг нэгнийхээ ашиг сонирхлыг чухалчилж, хүндэтгэлтэй ханддаг уу?	
3	Ямарваа нэг шийдвэр гаргахдаа харилцан зөвшилцөж, хамтын шийдвэрт хүрэхийг зорьдог уу?	
4	Өрхийн санхүүг хэрхэн зарцуулах талаарх шийдвэрийг хамтдаа гаргадаг уу?	
5	Та хоёр уур бухимдлаа барьж, маргаантай асуудлыг ч эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлздэг үү?	
6	Аль аль нь буруугаа хүлээж, бие биеэсээ уучлалт гуйдаг уу?	




Жендэрт суурилсан хүчирхийлэлд эрэгтэй, эмэгтэй хэн ч өртөж болох боловч ихэвчлэн охид эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж, гэр бүл, нийгэм, хамт олны дунд далд, нуугдмал хэлбэрээр орших нь түгээмэл байна.

### **БИЕ МАХБДЫН ХҮЧИРХИЙЛЭЛ**



- Цохих, зодох, өшиглөх гэх мэтээр ямар нэг байдлаар хэн нэгний биед гэмтэл учруулах;
- Үснээс татах, зулгаах;
- Хүний эсрэг буу, хутга, бусад зэвсэг ашиглан заналхийлэх;
- Алгадах, юм шидэх;
- Түлхэх;
- Нударгаараа эсвэл өвтгөж болох зүйлээр цохих;
- Өшиглөх, чирэх, зодох;
- Зориудаар хоолой боох, түлэх;

### **СЭТГЭЛ САНААНЫ ХҮЧИРХИЙЛЭЛ**



#### **Сэтгэлийн дарамт:**

- Хэл амаар доромжлох,
- Бусдын өмнө гутаан доромжлох
- Санаатайгаар айлгах, айлган сүрдүүлэх зүйл хийх (жишээ нь, муухай харах, орилж хашгирах, юм эвдлэх гэх мэт)
- Үгээр заналхийлж, сүрдүүлэх

#### **Захирах зан байдал:**

- Үргэлж хаана байгааг нь мэдэхийг шаардах
- Үл тоомсорлох, хайхрамжгүй хандах
- Өөр эрэгтэй/эмэгтэй хүнтэй ярихад уурлах
- Үнэнч биш байна гэж байнга сэжиглэх
- Эрүүл мэндийн үйлчилгээ авахад зөвшөөрөл авахыг хүсэх

#### **Хянах зан байдал:**

- Найз нөхөдтэй нь уулзуулахгүй байх
- Гэр бүлийнхэнтэйгээ холбоо тогтоохыг нь хязгаарлахыг оролдох
- Тухайн хүн үргэлж хаана байгааг мэдэхийг шаардах

### **БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ**




- Ойрын болон хамаатны гэр бүлийн хэн нэгэн хүсээгүй тохиолдолд бэлгийн харьцаанд орох, жишээ нь заналхийлэх, хүчээр барих, тухайн хүн үгүй гэж хэлэх боломжгүй нөхцөл байдалд оруулах замаар хүчирхийлэх;
- Хамтран амьдрагч/эхнэр, нөхөр хүсээгүй тохиолдолд бэлгийн харьцаанд орох;
- Хамтран амьдрагч/эхнэр, нөхрөөс айдаг тул хүсээгүй хэдий ч бэлгийн харьцаанд орох;
- Хамтран амьдрагч/эхнэр, нөхөр хүсээгүй эсвэл гутаан доромжилсон зүйлийг хүчээр хийлгэх;

### **ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ**



- Мөнгөтэй байсан ч өрхийн зардалд хангалттай мөнгө өгөхөөс татгалзах
- Гэр бүлийн орлогоо нуух, орлогоо захиран зарцуулах эрх мэдэлгүй байх
- Зөвшөөрөлгүйгээр мөнгө үрэх боломжийг хязгаарлах
- Ажил хийхийг болиулах, ажилд оруулахгүй байх





Гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь өрх гэр, орон байранд үйлдэгддэг, ихэвчлэн цусан холбоотой эсвэл хайр сэтгэлийн, дотно харилцаатай хүмүүсийн хооронд үүсдэг хэлбэр юм. Гэр бүлийн хүчирхийлэл нь эрх мэдэл, хүчний давуу талаа ашиглан, бусад гишүүдийг өөрийн эрхшээлд оруулах замаар хяналтаа тогтоодог. "Дотно харилцагчийн зүгээс үйлдсэн хүчирхийлэл" болон "Жендэрт суурилсан хүчирхийлэл" гэсэн нэр томъёо нь утгын хувьд зарим талаар давхцдаг.

Гэр бүлийн хүчирхийллийн зохирогч нь зөвхөн эмэгтэйчүүд байгаад зогсохгүй хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдаг.

- Таныг тэнэг, муухай, хэрэггүй амьтан гэх мэтээр дууддаг.
- Таныг үргэлж буруутгаж, юу ч болсон дандаа л таны буруу болдог.
- Тан руу үргэж эсвэл заримдаа чангаар орилж, цохиж дайрдаг.
- Таныг ямар нэг шийдвэрийг бие даан гаргах үед тэр үргэлж уурлаж бухимддаг.
- Таны хүүхэд ч бас айдас, түгшүүртэй амьдардаг.




*Хэрвээ та эсвэл таны эргэн тойронд хэн нэгэн хүчирхийлэлд өртөж байгааг мэдвэл цагдаагийн 102, хүүхэд хамгааллын 108 утсанд мэдэгдээрэй.*

### СЭДЭВ 3

# ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ ТАСЛАН ЗОГСООХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НЬ

Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдын дийлэнх нь тэр бүр хуулийн байгууллагад ханддаггүй. Тэд ихэнх тохиолдолд эргэн тойрны хүмүүсээсээ тусламж хүсч, дэмжлэг авах нь түгээмэл байдаг. Жишээлбэл, болсон явдлын талаар эхлээд гэр бүлийнхэндээ хэлж, дараа нь нийгмийн ажилтан, цагдаа гэх мэт хүмүүст ханддаг байна. Жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоохын тулд хүн бүрийн оролцоо чухал. Та дараах тохиолдлыг уншин, өөрийн оролцоогоо төсөөлөөд үзээрэй.



Хөрш айлынхан ахиад л зодолдсон бололтой. Урд шөнө бөөн уйлаан, майлаан болсон. Хүүхдүүдийг нь л өрөвдлөө.

Чи тэгээд цагдаад мэдэгдэхгүй яагаа вэ?

Эр эмийн хооронд илжиг бүү жороол гэдэг. Тэгээд ч нөхөр нь баригдаад явчихвал эхнэр нь дараа нь уурлаад байх ч юм билүү?

Үгүй дээ, хөгшөөн. Цаана чинь хүчирхийллийг таслан зогсоход хөршийн оролцоо чухал гээд яриад байгаа шүү дээ. Үүнээс болж хүүхдийн амь нас эрсэдсэн тохиолдол ч байгаа. Нийгэмдээ тустай хариуцлагатай байх нь ийм зүйлийг цаг тухайд нь мэдэгдэж байхаас эхэлнэ.

Нээрээ тийм шүү, нүдээ аниад өнгөрлөө гээд асуудал улам гүнзгийрч мэдэх юм байна.



*Энэ тохиолдолд та болон таны гэр бүлийн гишүүд юу хийж байсан талаар та гэр бүлийнхэнтэйгээ ярилцаарай.*

**Хаана хандаж, тусламж авч болох вэ?**



- Гэр бүлийнхэн



- Хүний эрхийн байгууллага



#102 - Цагдаагийн шуурхай утас 102



#108 - Хүүхдийн тусламжийн утас 108



- Аймаг, сумын цагдаагийн газар



- Эрүүл мэндийн байгууллага



**Хэрвээ та хүчирхийлэлд өртсөн бол**



• Юуг хүчирхийлэл гэх тал дээр сайн мэдлэгтэй байх ёстой. Тэгэхийн тулд ном, сонин их унших, найзуудтайгаа ярилцах, нийгмийн ажилтнаасаа асуух, бас интернэтээс мэдээлэл авч болно.



• Тусламжийн утсанд хандаарай. Ямар нэгэн дарамт, хүчирхийлэлтэй тулгарвал чамд тус болж болох байгууллагууд руу утасдаж, тусламж хүсээрэй.



• Цагдаагийн 102, 107, хүүхэд хамгааллын 108 гэх утаснууд танд зөвлөгөө мэдээлэл өгнө.



• Яаралтай үед хэрэг болох чухал дугааруудыг биедээ байнга авч яваарай. Түргэн тусламж: 103, цагдаагийн байгууллага 102, 107, онцгой байдлын газар 101 рүү утасдахад гар утаснаас чинь нэгж унахгүй. Нэгжгүй байсан ч холбогдох боломжтой. Та шалгаад үзээрэй



**Хэрвээ хэн нэгэн хүчирхийлэлд өртсөн бол:**



• Найздаа болон хэн нэгэнд туслахдаа түүнийг бүү буруутгаарай. Бид хэн нэгний амьдралыг шүүх эрхгүй. Эрсдэл үүссэн нөхцөлд зохих газарт мэдэгдээрэй!

• Тэр хүн ямар ч буруутай байсан хүчирхийлэл, дарамтад өртөх ёсгүй гэдгийг санаж яваарай!

**Монгол Улсын хуулиар хүчирхийлэгчдэд дараах хариуцлага хүлээлгэж, арга хэмжээ авдаг. Үүнд:**



- Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, дарамталсан, эдийн засгийн эрхэд нь халдсан бол албадан сургалтад хамруулж, долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна /Зөрчлийн тухай хууль/.

- Гэр бүлийн хүнийг байнга зодсон; харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан; хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд нь халдсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

- 18 наснаас доош насны хүнийг насанд хүрээгүй гэж үзэх бөгөөд насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн тохиолдолд 5-12 жилийн хорих ял эдлүүлнэ /Эрүүгийн хууль/.



## СЭДЭВ 4

# ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙДЭХ НЬ



Жендэрт суурилсан хүчирхийллийг төрүүлж байдаг нийгэм, соёлын нөлөөгөөр бий болсон жендэрийн хэвшмэл ойлголтын уршгаар хөвгүүд, эрэгтэйчүүд ч хүчирхийллийн хохирогч болдгийг санаарай!

Олон нийтийн дунд байдаг нэг хэвшмэл ойлголт бол эр хүн амьдралд хүчтэй, шийдэмгий, нугаршгүй, хатуу чанд, бие даасан байх ёстой гэсэн үзэл юм. Эрэгтэй хүүхдийг багаас нь хүчирхэг, хатуу чанд, шийдэмгий болгож өсгөх гэсэн хандлага нь зарим тохиолдолд хожмын нэгэн түрэмгийлэгч, дээрэнгүй үзэлтэн, өөрөөсөө дорой нэгэнд хүч хэрэглэгч нэгэн болгож төлөвшүүлэх тохиолдол ч бий. Хүчирхэг, шийдэмгий байна гэдэг нь нэг талаас хүний суурь хүмүүжил, төлөвшил, эрэгтэй хүний байгалийн өгөгдөл хэдий ч үүнийг хүчирхийллийн буруу хандлагатай андуурч ойлгож болохгүй. Нийгэмд эрэгтэй эмэгтэй хүмүүс эн тэнцүү, ажиллах амьдрах, хамтын үнэт зүйлсийг бий болгох, гадаад орчноос суралцах, хичээл зүтгэл, итгэл үнэмшилд тулгуурлан дээрх хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөх боломжтой юм. Тэгш байдлыг эрхэмлэгч, нийгмийн хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөхийг эрэлхийлж буй эрэгтэйчүүдэд ч мөн тусламж, дэмжлэг хэрэгтэй байдгийг анхаараарай.





Бид хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийг хүсч байгаа болажил, сургууль, гудамж талбай, өрх гэрт үүссэн хэвшмэл ойлголтоос татгалзаж, зөв, эрх тэгш соёл хандлагыг түгээх хэрэгтэй. Жаахан охидод өөрийн эрхээ мэддэг, биеэ хамгаалж чаддаг байхыг зааж, харин хөвгүүдэд бага наснаас нь эмэгтэй хүнийг эрх тэгш хүндэлдэг, ухаалаг харилцааг зааж сургахаас эхлэх ёстой юм. Мөн жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох хууль эрхзүйн орчин, бодлого хэрэгжих нөхцөл бололцоог шаардахад иргэн бүрийн оролцоо чухал.



Жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох нь нийгмийн гишүүн бүрийн үүрэг учраас та энэхүү хүчирхийллийг таслан зогсооход өөрийн боломжоор оролцоорой.



*Дараах дасгал ажлаар аль нь хүчирхийллийг таслан зогсоох оролдлого болохыг илэрхийлээрэй.*

№	Өгөгдөл	Тийм	Үгүй
1	Хүчирхийлэл гэж юуг хэлэх талаар уншиж судлах, бусдад түгээх		
2	Өөрийн хөвгүүдээ хүчирхийллээс ангид өсгөх, эмэгтэй хүнийг эрх тэгш хайрлах ухаанд сургах		
3	Ангийнхаа охины үсийг зулгаасан хүүгээ зэмлэх		
4	Хөршийнд сэжигтэй тохиолдол гарсан даруйд цагдаад мэдэгдэх		
5	Өөрөө хүчирхийлэлд өртмөгц цагдаад мэдэгдэх, арга хэмжээ авах		
6	Хүчирхийлэлд өртсөн нэгэнд сэтгэлийн болон эд материалын дэмжлэг үзүүлэх		
7	Хэвлэл мэдээллээр хохирогчийг буруутгасан хүчирхийлэлд өртсөн тухай мэдээг эсэргүүцэх		
8	Өөрийн тойргоос сонгогдсон гишүүнээс хүчирхийллийн асуудлаар ажиллахыг хүсэх		



***Зөв хариулт: Дээрх бүгд тийм буюу бүгд хүчирхийллийг таслан зогсооход таны оруулж болох хувьд нэмэр юм.***

***Танд амжилт хусье.***



Жендэрийн тухай агуулгыг уншиж судалсны дараа ойлголтын зөрүүгээ тодорхойлж, мэдлэгээ баталгаажуулаарай. Үндэслэл, тайлбар хэсэгт өөрийн бодлоо тодорхой бичээрэй.

№	Асуулт	Эрэгтэй	Эмэгтэй	Үндэслэл, тайлбар
1	"Тогооч"-ийн ажлыг ямар хүйсийн хүн хийвэл тохиромжтой гэж боддог вэ?			
2	"Инженер"-ийн ажлыг ямар хүйсийн хүн хийвэл тохиромжтой гэж боддог вэ?			
3	Үр хүүхдээ өсгөж, хүмүүжүүлэхэд эхнэр, нөхрийн хэн нь голлох үүрэгтэй байх ёстой гэж боддог вэ?			
4	Эхнэр нөхрүүд гадуур мал аж ажуйн ажлаа хийж ирээд хэн нь гэрийнхээ ажлыг түлхүү хийх үүрэгтэй вэ?			
5	Аль хүйсийн хүмүүс зайлшгүй боловсрол эзэмших ёстой гэж боддог вэ?			



